

ГЕРМАН ДАХЬ МОНГОЛЫН БИЧИГ СОЁЛЫН ӨВ

Ж.УРАНГУА

Товч агуулга: Монгол судлал Германд анх хэл шинжлэлийн чиглэлээр тэртээ XVIII зуунд үүсэж хөгжсөн бөгөөд тэр үеийн цуглуулагч, судлаач Х.А.Цвик, Вильхелм Шотт, Бернхард Юүлг, Эрих Хэниш нар балрашгүй үл мөрөө үлдээсэн билээ. Өдгөө Германд Монголын бичиг номын их өв хадгалагдаж байна. Германы цуглуулагчид, жуулчдын Монголын түүх соёлын дурсгалуудыг янз бүрийн хугацаанд олж цуглуулсан агаад цуглуулгын дийлэнх хэсэг нь XVIII зуун болон XIX зууны эхэн үеийнх агаад XX зууны эхэн үед холбогдох Монгол нутгийн газрын зургууд мөн үүнд багтах аж. Эдгээр үнэт өвийг тайлбарлан таниулах нь шинжлэх ухааны түүхийн нэгээхэн хэсэг билээ. XVIII-XX зууны эхэнд тус орны цуглуулагчид, аялагчид монголчуудын бичиг үсгийн соёлд холбогдох арвин их дурсгалыг цуглуулж чадсан нь өдгөө хадгаламжийн хэмжээгээрээ ОХУ-ын дараа орохуйц болжээ. Миний бие энэхүү өгүүлэлдээ ХБНГУ-д хадгалагдаж буй монгол соёлын өв, тэд чухам хаана хадгалагдаж байгаа болон тэдгээрийг хэн хэдийд тус улсад аваачиж номын сангийн цуглуулгыг баяжуулсныг дэлгэн тавих болно. Чингэхдээ Германд хадгалагдаж буй монгол ном судар болон газрын зургийн талаар Германы монголч эрдэмтэд болох Вальтер Хайсиг абугай Клаус Загастерийн хамт туурвисан каталог ном болон М.Халтодын Монголын газрын зургийн каталог, газар усны нэрийн хэлхээсийг гаргасан каталог номуудад¹ тулгуурлан гаргасан болно. Мөн бусад орнуудад хадгалагдаж буй монгол бичиг соёлын өвийн талаарх мэдээллийг² оруулсан нь танин мэдэхүйн зорилгоор хийгдсэн болно. Европ дахь монгол соёлын өв нь судалгаа шинжилгээний ажлын суурь дэвсгэр болж үе үеийн судлаачдын оюуны сүвийг сэтгэж, тэрний хирээр Монгол судлалын цагаан мөр үл тасарна. Монгол ном шастирыг шинжлэх ухаан, ном бичгийн түүхийн үүднээс системтэй авч үзэх үйлсэд зориулан энэхүү өгүүллийг тэрлэхэд Хайсиг, Загастр нарын хийсэн каталогийн баримтын орчуулга чухаг үндэс болсныг дахин цохон тэмдэглэе.

Түлхүүр үг: монгол, өрнөд, ном, судар, цуглуулга, танилцуулга ХБНГУ дахь Монголын түүх-соёлын өв

¹ MONGOLIAN NANDSCHRIFTEN BLOCKDRUKE, LANDKARTEN. Beschrieben von Walther Heissing Unter mitarbeit von Klaus Sagaster. Mit 16 Lichtdrucktafeln. Franz Steinar Verlag GMBN-Wiesbaden, 1961; MONGOLISCHE ORTSNAMEN. Aus mongolischen manuscript-karten zusammengestellt von Magadburin Haltod. TEIL mit einer einleitung von Walther Heissing. Mit 26 lightdrucktafeln. Franz Steiner Verlag GMBN. Wiesbaden 1966

² CATALOGUE OF MONGOL BOOKS, MANUSCRIPTS AND XYLOGRAHS by Walther Heissing, assisted by Charles Bawden. The Royal Library Copenhagen 1971; А.Г.Сазыкин. КАТАЛОГ МОНГОЛЬСКИХ РУКОПИСЕЙ И КСЕЛОГРАФОВ Института Востоковедения Академии Наук СССР. Том 1-3. Москва

Өдгөө Германы нэр бүхий газрын 12 номын сан болон музейн цуглуулгуудад монгол, халимаг, буриад гар бичмэл, барын хэвлэл, газрын зургууд хадгалагдаж байна. Тэдгээрийг дурдвас:

Берлин: Хуучин Пруссийн Улсын номын санд байсан монгол гар бичмэл, барын хэвлэлүүд одоо Марбург дахь Баруун Германы номын сан (Хуучин Пруссийн Улсын номын сан) болон Тюбингений Их сургуулийн номын сан (Хуучин Пруссийн Улсын номын сангийн сан хөмрөг)-д

Берлин: Германы Шинжлэх Ухааны Академи – Угсаатны зүйн музей

Дрезден: Саксоны Улсын номын сан

Гёттинген: Доод Саксоны Улсын болон Их сургуулийн номын сан

Лайпциг: Их сургуулийн номын сан – Угсаатны зүйн музей

Майнц: Шинжлэх Ухаан, Уран зохиолын академи

Марбург: Баруун Германы номын сан (өдгөө Берлины Улсын номын сан)

Мюнхен: Баваарын Улсын номын сан - Угсаатны зүйн музей

Штутгарт: Линден музей

Тюбинген: Их сургуулийн номын сан дахь Хуучин Пруссийн Улсын номын сангийн сан хөмрөг зэрэг болно.

Германы цуглуулагчдын үйл хэрэг

Георг Томас фон Ааш

Гёттингений Шинжлэх Ухааны Академид тус академийн ивээн тэтгэгч барон Георг Томас фон Ааш (1729-1807)-ийн авч өгсөн монгол, халимаг гар бичмэлүүд Германы монгол цуглуулгын эхийг тавьжээ. Оросын армийн ерөнхий эмч, Санкт Петербургт Оросын төрийн зөвлөх хийж байгаад 1807 оны 6-р сарын 23-нд нас нөгчсөн фон Ааш өөрийн суралцаж байсан Гёттингений их сургуулийг насан туршдаа ихэд дотночилон үзэж байжээ. Тэрээр Их Петр хаан Хааны номын санд зориулж нэлээд тооны монгол, төвд ном шастир худалдан авахуулснаас хойш Оросод монгол гар бичмэл цуглуулах болсон бөгөөд тэдгээр нь 1720 онд Эрчис дэх нурж сүйдсэн *Аблайн хийдээс* олдсон байна³. Тэр үед ийм цуглуулга хийхийг ихэд сонирхдог байсныг барон фон Ааш өлгөн авч, 1778-1790 онд монгол, халимаг 33 гар бичмэлийг Гёттингенд илгээсэн нь өнөөдөр Доод Саксоны Улсын болон Их сургуулийн номын сан дахь Аашийн цуглуулгад хадгалагдаж байна.

³ De Scriptis Tanguticis in Sibiria repertis commentario Ger. Fr. Mülleri, Commentarii Akad. Imp. Petr., X, St. Petersburg 1747, 420; B.Dorn, das Asiatische Museum der Kaiserl. Akademie der Wissenschaften zu St. Petersburg, St. Petersburg 1846, 2; Л.С.Пучковский, Собрание монгольских рукописей и киелографов, Ученые Записки Инст. Востоков., IX: 1954, 91

Фон Ааш нь их төлөв Санкт Петербургт сууж байсан учир тэдгээр халх монгол болон ойрадын бүтээлүүдийг өөрөө цуглуулаагүй аж. Тэрээр уг албыг хашиж байхдаа төдийлөн нээлттэй болоогүй байсан Сибирь, Монголын хил хязгаар нутаг болон Халимагийн тал нутгаар Оросын даалгавраар аялдаг байсан эрдэмтэд (ихэвчлэн герман гаралтай)-тэй холбоотой байсан бөгөөд тэд нараар ном шастир, угсаатны зүйн холбогдолтой цуглуулгын зүйлс авчруулдаг байжээ. Оросын хаант төрд зүтгэж байсан агаад Сибирийн түүхийг судалдаг Герхард Фридрих Мюллер⁴ нэгэн хуучин архиваас⁵ олсон нэг монгол шастир, тэрчлэн 1788 онд буриадуудад цэцэг өвчний тарилга хийж байсан мэс заслын бага эмч Иоханн Шиллингийн тайлан мэдээг худалдаж авсан байна.

“Пайнагийн уугуул”, 1795 оны 4 сарын 6-нд Санкт Петербургт нас барсан эмийн санч Иоханн Август Сийверс түүнд Хиагт хавиас нэг “боодол монгол ном шастир”⁶ авчирч өгсөн бол халимагуудын дунд ажиллаж байсан Херрнхутийн шашин номлогчдын нэг болох нэрийг нь эс дурьдсан “Морави ах/дүү” түүнд зориулж Ижил мөрний дэргэдэх Саратовт нэг судар⁷ хуулж өгсөн байна. Гэхдээ фон Ааш Хессений уугуул, өөрийгөө “Веттерау, Изенбург-Бюденгений гүнлигийнх ... Оросын Хааны Шинжлэх Ухааны Академид янз бүрийн монгол хэлний орчуулагч хийдэг” хэмээн хэлдэг байсан И. Еэриг-ээр дамжуулж монгол, халимаг гар бичмэлүүдийн ихэнхийг олж авсан болов уу хэмээн германчууд үздэг байна.

Иоханн Еериг бол байгалын түүх судлаач 1773-1774 онд П. С. Палласын (1741-1811) Монголд хийсэн аялалд оролцсоны дээр түүний алдарт “Монгол туургатны талаарх түүхэн мэдээ мэдээллийн цуглуулга”-д хувь нэмрээ оруулсан хүн юм. Тэр гол төлөв Оросын Шинжлэх Ухааны Академид монгол гар бичмэл цуглуулж өгдөг байсан⁸ бөгөөд тус Академид зориулан “Орос сэтгүүл”⁹-д товч тодорхойлолтыг нь урьдчилсан байдлаар гаргаж байжээ.

Барон фон Аашийн Гёттингений Академитай солилцож байсан захидлууд¹⁰-ад хадгалагдан үлдсэн жагсаалт, тэнд бичсэн зүйлсээс үзэхэд Аашийн цуглуулгын ихэнх монгол, халимаг бичвэрийг 1781, 1790-92, 1794-95 онуудад олж авсан

⁴ Хаант Оросод зүтгэж байсан, герман гаралтай эрдэмтэн

⁵ Liste von Asch vom 4. August 1778

⁶ Brief von v. Asch an Hofrat Heyne, Göttingen, vom 2./13. Dezember 1795

⁷ Cod. Ms. Asch 154c

⁸ Л.С.Пучковский, Собрание, Учёные Зап. Инст. Востоков., IX: 1954, 93; В.Дом, Das Asiatische Museum, 1846, 9-10

⁹ Jahrgang, 1789, 2. Band, 126-134. “Verzeichnis des Inhaltes Mongolischer und Tübetischer theils gedruckter, theils geschriebener Bücher und Schriften ..., gesammelt durch Johannes Jählig“

¹⁰ Cod. Ms. Asch A, I/II

байдаг. Тэр үед Иоханн Еериг (1747-1847) их төлөв Хиагтын дэргэдэх *цорж Цэдэвийн* сүмд суудаг байжээ. Түүнийг тэндээс буцсаныхаа дараа 1795 онд Санкт Петербургт нас барахад фон Ааш тэр тухай Гёттинген рүү Хайне-д: “Монгол хэлний орчуулагч Иоханн Еэриг Хиагтаас буцаж очсон даруйдаа 95 оны 6 сарын 15/26-нд нас нөгчлөө. Манай химич ноён Ловитцын эгч/дүү болох бэлбэсэн эхнэр нь хүүхэд ч үгүй, хөрөнгө зоорь ч үгүй хоцорлоо”¹¹ хэмээн мэдээлсэн буй. Еэригийг өнгөрснөөс хойш фон Ааш ч Гёттингений Шинжлэх Ухааны Академид монгол ном судар явуулахаа больжээ. Тэдгээрийг анх “Прусс улсын Гар бичмэлийн бүртгэл”-д тодорхойлсон бөгөөд хожим заримыг нь Б.Лауфер “Монгол утга зохиолын найруулал”¹²-даа дурьдсан байна.

Хенрих Август Цвик

Голландад төрсөн, Петербургт Оросын төрийн зөвлөх байхдаа 1847 оны 9 сарын 8-нд таалал төгссөн хуучин шашин номлогч Исаак Якоб Шмидт (1779-1847) монгол түүхэн шастир *Эрдэнийн товч* (1662 онд Ордосын Саган эцэн хунтайжийн зохиосон-Ж.У.)-ийг 1829 онд хөрвүүлж нийтлүүлснээс хойш герман хэлтнүүдийн амьдардаг нутаг оронд Монголтой холбоотой зүйлс, монгол ном зохиолыг сонирхох сонирхол нэмэгдсэн байна.

1823 оноос өмнө халимагуудын дунд амьдарч, “Баруун монгол хэлний дүрэм”¹³ болон “Баруун монгол хэлний гарын авлага” -ыг зохиосон Херренхутын шашин номлогч Х.А.Цвик (1796-1855) Ойрадаас нэлээд хэдэн гар бичмэл авчирч Дрездений халимаг гар бичмэлийн цуглуулгын үндэс суурийг тавьжээ. Өдгөө Дрезден дэх Саксоны Улсын номын санд хадгалагдаж буй тэр үеийн бичиг баримтад: “Ноён Цвикийн дорно дахины холбогдолтой арвин баялаг цуглуулгаас буддын ном судрын төвд, халимаг, монгол хэл дээрх 70 гар бичмэл эхийг 1839 онд худалдан авсан. Хуучин шашин номлогч байсан, одоо Эберсдорфийн Ахан дүүсийн чуулганы тэргүүн ноён Цвик бол Дундад Азийн тал нутгийн ард түмнүүдийн дунд өндөр мэдлэг мэргэжлийнхээ дагуу 20 жил амьдрахдаа угсаатны зүй, хэл шинжлэлийн холбогдолтой бүхий л этгээд сонин, соёлын зүйлсийг олж авах боломжийг алдалгүй өнгөрөөгөөгүй хүн юм” хэмээн дурьдсан амуй. Х.А.Цвик өөрөө 1851 онд хэвлүүлсэн “Баруун монгол хэлний дүрэм”-ийн өмнөтгөлд халимагуудын дунд өнгөрүүлсэн цаг хугацаа болон цуглуулгынхаа

¹¹ Brief vom 2./13. Dezember 1795 aus St. Petersburg

¹² Keleti Szemle VIII: 1907, 165-260

¹³ Намтар нь Баденд 1851 онд хэвлэгдсэн

ажлын талаар: “Харин 28 жилийн тэртээгээс миний бие энэ ард түмнээс бүхий л холбоогоо тасалсан ба 15 жилийн өмнө сүүлчийнхийг нь харсан болохыг харгалзан үзвэл зохино” гэжээ. Ийн дурьдсанаас нь үзвэл тэр 1823 оноос өмнөх он жилүүдэд халимагуудын дунд цуглуулга хийж байсан байж таарч байна. Дэлхийн хоёрдугаар дайны үед сүйдэхээс сэргийлэн найдвартай газар аваачсаны ачаар Дрезден дэх Цвикийн халимаг бичвэрүүдийн цуглуулга Дрездений аймшигт хувь заяанд өртөөгүй байна. Хайсиг абугайн тэмдэглэснээр, Юүлг буюу Лауферийн мэдээлэлтэй хийсэн харьцуулалтаас зарим эх хувь нь алдагдсан болох нь харагдана, гэхдээ бидэнд ядаж л Б. Юүлгийн хуулсан хувиудад бичвэр нь үлдсэн буй гэжээ.¹⁴

Август Цвик нь Оросын Царицыны ойролцоох Сарептед орших герман колонид 1822-1836 онуудад амьдарч, лютеран шашин түгээх нийгэмдэг байгуулан ажиллаж байхдаа халимагуудын нутгаар хэд хэдэн удаа аялж энэ тухайгаа ном бичиж үлдээсэн байна. Мөн тэрээр Алтан Ордоны улсын зоос мөнгө цуглуулсан ба Алтан Ордоны нийслэл Сарай хотоос олдсон үлэмж хэмжээний алтан эдлэлийг (Жанибекийн титем хэмээн алдаршсан-Ж.У.) худалдан авч, тэр бүхнээ Герман руу илгээж байжээ. Цвик нь мөн археологийн малтлага хийж Сарептагаас хүрлийн үед холбогдох 2 булш малтан элэм бүхий олдворууд илрүүлжээ.

Вильхелм Шотт

Берлиний Их сургуулийн алдарт Дорно дахин болон Алтай судлаач, Майнцын уугуул Вильхелм Шотт (1802-1889) хожим Пруссийн Улсын номын сан болсон Берлин дэх Хааны Номын санд зориулан 1863 онд нэрийг нь эс дурьдсан хувийн эзэмшлээс 6 халимаг (ойрад-Ж.У.) гар бичмэл худалдаж авсан байна.¹⁵ Үүгээрээ тэр тус номын санд монгол ном шастир цуглуулах үндэс суурийг тавьсан юм. Улмаар Монголч эрдэмтэн Б. Юүлгийг нас барсны дараа 1887 оноос түүний монгол, халимаг гар бичмэл, хуулбаруудын цуглуулгыг нь худалдан авах болсны дүнд тэдгээрийн тоо хэмжээ үлэмж нэмэгдсэн байна. В.Шотт бол Берлины их сургуулийг төгссөн, тус сургуулийн профессор агаад дорнын олон хэл эзэмшсэн, Гэсэр судлалд том хувь нэмэр оруулсан Германы нэрт Дорно дахин судлаач юм. Түүний бичсэн хятад хэлний дүрмийн сурах бичиг олон жилийн туршид Германд өргөн хэрэглэгдэж байжээ.

¹⁴ Хайсаг; Загастер. Дурьдсан ном, т.13

¹⁵ Ms. or. fol. 1595-1599

Бернхард Юүлг

Бернхард Юүлг (1825-1886) Дрездений номын сангийн хөмрөгт байсан ном судруудыг маш нарийвчлан хуулж, тулган үзэж байсны дээр өөрөө монгол, юун түрүүнд халимаг ном судар цуглуулдаг байв. Тэрээр юуны өмнө *Шидэт хүүрийн* үлгэрүүд, *Арж Борж хааны намтар* (32 модон хүний үлгэр) зэргийн монгол хувилбар дээр ажиллаж, хийж байсан орчуулгатай холбоотойгоор цаг үеийнхээ тэргүүлэгч монголч эрдэмтэдтэй санаа бодлоо идэвхтэй солилцож байжээ. Түүнд, дээр дурдсан Исаак Якоб Шмидт (1847) нас барахаасаа нэг жилийн өмнө үнэ цэгтэй халимаг гар бичмэлийн цуглуулга¹⁶ бэлэглэсэн бол эрдэмтэн лам Галсан Гомбоев *Арж Борж* хааны намтрын гар бичмэлийг хуулан өгч, Ж.Е.Ковалевский 1866, 1867 онуудад Санкт Петербургээс мөн тийм гар бичмэлийг хуулж ирүүлсэн нь Б. Юүлгийн “Монгол үлгэрүүд” (1869 онд Иннсбрукт хэвлүүлсэн)-эд нийтлүүлсэн *Арж Борж хааны* намтрын хэсгүүдийн үндэс болсон байна.

Ханс Конон фон дер Габеленц (1807-1874)-ын хуучин эзэмшилд байсан нэгэн монгол гар бичмэлийн дагуу хийсэн *Гисэнэ хааны* түүхийн герман хэл дээрх орчуулга ч бас Юүлгийн номын санд байжээ. Энэхүү монгол гар бичмэл болон Габеленцын эзэмшилд байсан бусад гар бичмэл хэрхэсэн нь тодорхойгүй. Б.Юүлгийн гарт байсан Чингис хааны талаарх туурвилын өөр нэг гар бичмэл монгол гар бичмэл цуглуулдаг эрдэмтэн Шиллинг фон Каннштадт (1786-1837)-ынх байсан бөгөөд аялалынх нь маршрутаас харахад¹⁷ тэр уг гар бичмэлийг Монгол-Ойрадын хил залгаа нутгаас олж авсан байж болохоор байна хэмээн Хайсиг, Загастер нар үзжээ. Б. Юүлгийн өв дэх гар бичмэлүүдийн нэлээд нь халимаг, монгол ном судрын тасархай хуудаснууд, зарим нь XVII зууны үеийн ихэд бохирдож, зарим хэсэг нь шатсан, шавар шорооны ул мөр үлдсэн хуучин бичвэрүүдийн үлдэгдэл¹⁸ байна хэмээн Хайсиг бичсэн байна. Тэр бүхнийг цуглуулгын хавтсанд хадгалж иржээ. Чингэхдээ тасархай хэсгүүдийг тодорхойлохыг оролдсон ч тэр бүр бүтээгүй байна. Бернхард Юүлг тэр олон тасархай хэсгийг хэнээс авснаа хэлээгүй аж. Монгол, халимаг хэл дээрх ном судруудыг бичсэн хэлний шинж, тэдгээрийн насжилтаас харахад Умард Монгол-Ойрадын хил хязгаар нутгаар аялж явсан жуулчин хүн л тэндээ тэдгээрийг олж авсан байх магадлалтай гээд тэрбээр цааш нь: “...ийн санамагц тэр бичвэрүүдийг тэндээс олж авсныг нотолсон ч нотлоогүй ч 1845-1849 онуудад Хятадын хилээс гарч Сибирээр аялсан М.А.Кастрен (1813-1852) –ы нэр санаанд орно. Кастрены өвлүүлсэн хэл шинжлэлийн бүтээлүүдийг

¹⁶ Abbildung 10; Ms. or. quart. 765; В. Jülg, Die Märchen des Siddhi-Kür, Leipzig 1866, XI

¹⁷ Н.Поппе, Летописи селенгинских Бурят, Труды ИВАН XII, Москва 1936, 37

¹⁸ Ms. or. oct. 422; Ms. or. quart. 769; Ms. or. quart. 770; Ms. or. quart. 771; Ms. or. quart. 772; Ms. or. fol. 1590; Ms. or. fol. 1591; Ms. or. fol. 1592; Ms. or. fol. 1593; Ms. or. fol. 594

хэвлүүлж, Б.Юүлтэй ч бас захидлаар харилцаж байсан Антон Шийфнер (1817-1879) зуучлагч нь байсан байж магадгүй”¹⁹ хэмээн цохон тэмдэглэжээ.

Цуглуулагч нарын олж ирсэн тийнхүү их олноороо гарч ирсэн хуучны гар бичмэлийн тасархайн эхлэл, төгсгөл ихэвчлэн алга болсон, гал юмуу усанд өртөж гэмтсэн байдалтай байгааг ажиглан, тэр нь буюу тэдгээр эрээвэр хураавар бичгийн зүйлс нь тэдгээрийг Монголын шарын шашны томоохон хийдүүдийн ойролцоо байх сувраганд хийсэн байсныг илтгэх ба тийм бунханд сүсэгтнүүд хэрэггүй болсон ариун судрын гар бичмэлийг устгахгүйн тулд “бурханы зарлигийг бишрэн дээдэлж” хийдэг байсныг гадныхан гярхай ажиглажээ. Тэд, Дунхуаны агуйн сүмүүдэд ч бас энэ заншлыг баримталж байв.²⁰ Умард Монгол-Ойрадын нутагт нэг юмуу хэд хэдэн тийм *бунханд* байсан зүйлсийг нэр нь үл мэдэгдэх цуглуулагч авчирч, Бернхард Юүлгийн цуглуулгыг шарын шашны баруун монгол, монгол хэл дээрх тэрхүү олон сонирхолтой судар номын тасархайгаар баяжуулж өгсөн нь тэр ажээ хэмээн дүгнэн бичжээ.

Бар номын цуглуулга

Тухайн үедээ Ордны Төв номын сан хэмээн нэрлэгдэж байсан Мюнхен дэх Баваарын Улсын номын сан ч бас 1877 онд Францын Дорно дахины судлаач Этьенн Картмерийн их төлөв хятад бичиг номоос бүрдсэн номын санг худалдаж авснаар Бээжинд барласан зарим монгол ном хэвлэлийг эзэмших болсон байна.²¹ Монгол Ганжуурын Юмын аймгийн 12 ботийн уран бичлэгээр үйлдсэн 1705 оны гар бичмэлийг Пруссын Улсын номын сан 1892 онд худалдан авч монгол сан хөмрөгөө үлэмж их баяжуулсан байна.

Худам монгол хийгээд пагва үсгээр үйлдсэн XIV зууны үсийн гар бичмэл болон дармал хэвлэлийн 25 тасархай хуудсыг 1905 онд Идикут-шарид олох завшаан А.фон Ле Кок, А.Грюнведель нарын удирдсан Пруссын Турфаны экспедицид тохиолдсон юм. Тэдгээрийг өдгөө Берлин дэх Германы Шинжлэх Ухааны Академи, Берлин-Даалем дахь Угсаатны зүйн музей болон Майнц дахь Шинжлэх Ухаан, Утга зохиолын Академид хадгалж байна. Эдгээрийн хуулбаруудыг нь хэвлэн гаргасан байна.²²

¹⁹ Хайсаг, Загастер, т.14

²⁰ A.STEIN, Serindia, II, London 1921, 814

²¹ F.J.MEIER, Aus der Geschichte der Asia major-Bestände der Bayerischen Staatsbibliothek und ihrer Bearbeitung, Orientalisches aus Münchener Bibliotheken und Sammlungen, Wiesbaden 1957, 44-45

²² E.Haenisch Mongolica der Berliner Turfan-Sammlung, Berlin I, 1954, II, 1959

XX зууны эхэн үеийн цуглуулагчид

Берлин дэх Пруссийн Улсын номын сангийн буриад барын 38 хэвлэлийн цуглуулга 1900 оны эхний жилүүдэд бий болжээ. Берлины хятадач Вильхелм Грубегийн 1900 онд Бээжингээс худалдаж авсан²³ Хятадын Fan-t'ang уен-yi романы монгол хэл дээрх орчуулгын гар бичмэл түүнийг нас барсны дараа Лайпцигийн Их сургуулийн номын сан (VII-VIII)-д ирсэн бөгөөд тус номын сан нь түүнээс гадна XX зууны эхэн үеийн Монголын металл барын хэд хэдэн хэвлэлийг эзэмшдэг байна.

Тэрчлэн тус зууны эхний он жилүүдэд Троппаугийн уугуул, шинжилгээ судалгааны ажлаар аялдаг байсан Ханс Ледер (1843-1921) цуглуулгын ажил эрхэлж байжээ. Тэрээр 1903 онд Төвд-Монголын хил нутаг болон Монголд судалгааны аялал хийж, тэр тухайгаа 1909 онд “Нууцлаг Төвд орон, Далай ламын оюун санааны гүрэнд хийсэн аялал”-даа мэдээлсэн байна. Өргөө буюу өнөөгийн Улаанбаатарт Ледер нэлээд хугацаагаар байсан агаад тэрхүү аялалын үеэр цуглуулсан төвд, монгол урлаг, бурхан шүтээний холбогдолтой 20 мянга гаруй эд зүйлсийнх нь дотор байсан монгол гар бичмэл, барын хэвлэлийн дийлэнх нь тэндхийнх юм. Тэдгээр монгол ном судрыг худалдан авах замаар Штуттгарт дахь Линден музей²⁴ болон Лайпцигийн Угсаатны зүйн музей²⁵-н цуглуулгад оруулжээ. Дараагийнх нь жилүүдэд Штуттгартын Линден музей дэх Ледерийн цуглуулгын монгол гар бичмэлүүд дээр И.Ф.Г.Умлауфф (Хамбург)-ын цуглуулгын сан хөмрөгөөс гар бичмэл нэмэгдсэн байна. Умлауффын пүүс тэдгээрийг Төв Азид аялсан Свен Хедин (швед, 1865-1952), Альберт Тафель, Вильхелм Фильхнер нараас худалдан авсан гэдэг²⁶. Үүнийг Хайсаг бичихдээ, тэр нь Өвөр Монголын баруун, Төвд-Монголын хил нутгийнх болох нь тэр гурван судлаачийн аялалын маршрутаас харагдана гэжээ.

Хединий экспедицийнхний 1927-1935 онд цуглуулсан Шведийн Этнографийн музей дэх олон тооны монгол ном судрыг П.Аалтогийн тодорхойлсноор²⁷ Свен Хедин үе үе боломжоороо худалдан авч байсан аж.

²³ Zur Pekinger Volkskunde, Berlin 1901; B.Lauffer, Skizze der mongolischen Literatur, 234

²⁴ Leder 24 351 C 1-C5; 24 395; 23866; 23 944; W. Heissig, Mongolisches Schrifttum im Linden-Museum, Tribus VIII: 1959, 39-56

²⁵ F III 60-67; M. Taube, Verzeichnis der Tibetica des Leipziger Museums für Völkerkunde, Jahrbuch des Museums für Völkerkunde zu Leipzig; XVII: 1958, 93-139

²⁶ R.O.MEISEZAHN, Die tibetischen Handschriften und Drucke des Linden-Museums in Stuttgart, Tribus VII: 1957, 5). Тэдгээр гар бичмэл (Umlauff 71 305; 71 345; 71 365; 71 366; 71 367; 71 368; 71 369; 71 372; 71 374; 71 197

²⁷ A Catalogue of the Hedin Collection of Mongolian Literature, Stockholm 1953 (Reports from the Scientific Expedition to the North-Western Provinces of China. Publ. 68), 69-108

Берлин-Даалемын Угсаатны зүйн музейд хуучин музейн сан хөмрөгт байсан хэд хэдэн ном шастир байгаагийн дотор Герингийн Халимагийн шинжилгээний ангийнхны бүр 1897 онд худалдаж авсан нэгэн халимаг барын хэвлэл байгаагийн зэрэгцээ тэр үед Берлиний Их сургуулийн профессор байсан Ф. Д. Лессинг (Berkeley, USA)-ийн Хединий экспедицийн бүрэлдэхүүнд орж 1930-34 онд²⁸ Өвөр Монгол болон Бээжингээс Берлиний Угсаатны зүйн музейд цуглуулж өгсөн монгол барын хэвлэл болон гар бичмэлүүд ч байна.

1936 онд тэр үед Берлиний Хятад судлалын тэнхимийн эрхлэгч байсан Эрих Хэниш (1880-1966) Хятад болон Монголд хоёр дахь удаагаа аялахдаа Бээжингээс тэнд барласан олон тооны хэвлэл авчирсан байжээ. Ялангуяа 1928 онд Монголоор аялж явахдаа Улаанбаатар дахь номын сангаас Саган Сэцэний Монголын түүхийн гар бичмэлийг анх үзжээ. Энэ нь түүний хувьд урьд өмнө үзэж байсан гар бичмэлээс хамгийн бүрэн төгс бичмэл байв. Тэрээр дараа нь уг гар бичмэлийг хэвлэсэн нь Монгол судлалд томоохон хувь нэмэр болсон юм.

Херман Констен (1878-1958) Монголоор хэд хэдэн удаа аялж алдаршсан тэрбээр²⁹ 1946 оныг хүртэл Хятадад байхдаа хэдэн монгол бүтээл цуглуулжээ. Констен юуны өмнө монгол гар бичмэл-газрын зураг их хэмжээгээр цуглуулж чадсан байна. Тэдгээр газрын зураг нь 1907 онд (Бадаргуултын 33 дугаар он) Шинэ засгийн бодлогын хүрээнд Гадаад Монголын төрийг засах явдлын яамны тушаалын дагуу хийгдсэн Монголын бүх хошуу нутгуудын газрын зургууд байна. Манж нар тус газрын зураг дээр газар усны нэрийг хятад үсгээр тэмдэглэсэн наалт хийсэн байна (15.000 газрын нэрийг хэмээн Г.Дорис авхай тэмдэглэжээ) Тэрхүү цуглуулга, мөн түүний цуглуулсан бусад ном шастир нас барсных нь дараа Марбург дахь Баруун Германы номын санд очжээ. Хоёр Герман нэгдсэнээс хойш энэ нь одоогийн Берлины Улсын Номын сан юм³⁰.

Берлины Улсын номын сан дахь Монголын газрын зурагнууд засаг ноёдын эзэмшлээр зурсан байх агаад Монголын нутаг бэлчээрийн зургууд аж. Чин улсын Бадаргуултийн үеийн Германд байгаа Монголын газрын зурагнуудыг Хайсигийн шавь, хамтран зүтгэгч доктор Клаус Сагастер мөн М. Халтод нар судалжээ. Газрын зургууд нь манай зууны эхэн үеийн Монголын газар нутгийн харилцааны талаар нарийвчилсан төсөөллийг өгч буйн дээр Монголын газар усны нэрийг судлахад

²⁸ Er berichtete über seine Reise in seinem Buch: Mongolen, Hirten, Priester und Dämonen. Berlin, 1935

²⁹ Weideplätze der Mongolen, 2 Bde, Berlin 1919-1920

³⁰ Тус номын сан дээр "Ази даяар" гэх төсөл хэргэжиж байгаа бөгөөд түүний үр дүнд Ази судлалын ямар бүтээл хаанахын ямар номын санд ямар хэлбэрээр, хэдэн хувь байгааг харж болох аж. Цахим хаяг нь <https://crossasia.org>; <https://themen.crossasia.org/mongolische-karten>

үнэлж баршгүй чухал материал болжээ. Газрын зурагнууд нь Чингийн Бадаргуулт төрийн үеийнх бөгөөд мөн 1919 оны зураг бас буй.

Нэгэн зүйл

Монголын уран зохиолын түүх, орчуулгын ном зохиолын хөгжил хийгээд тогтсон дэг жаягт ороогүй ардын мөргөл залбирлын ном зохиолын судалгааны хувьд Германы цуглуулгад байгаа бүтээлүүдээс үнэ цэнтэй санаа оноо авч болох юм. Тэгээд ч тодорхойлолтыг нь гаргасан ном шастируудын ихээхэн хэсэг нь аль XVIII зууны эцэс, XIX зууны эхэн үеийн цуглуулгынх байгаагаараа чухал ач холбогдолтой агаад энэ нь Монгол судлал Өрнө дахинд хөгжихийн нэгэн үндэс суурь болж өгчээ.

Халимаг-Ойрад гар бичмэлүүд үлэмж хэмжээгээр хадгалагдаж байгаа нь Германы гар бичмэлийн сан хөмрөгийн нэг гол онцлог байна. Ойрад судлал Өрнөдөд Монгол судлалын хамгийн их хөгжсөн салбаруудын нэг гэж Н.Поппе үзжээ³¹. Германд Ойрадын бичиг соёлд хамаарах олон дурсгал өнөө үеийн судлачаа хүлээн өдгөө хадгалагдаж байна.

Ингээд Хайсаг болон Загастрын хийсэн нь каталог нь Марбург, Тюбинген дэх Юүлгийн цуглуулгад байсан “тодорхойлохын аргагүй” гэгдэж байсан олон тасархайн бүрэн бүтнээрээ байгаа буюу гол хэсэг нь (гарчиг, төгсгөлийн тайлбар) сайтар хадгалагдан үлдсэн, өмнө нь хянан боловсруулж, ашиглаж байсан хүмүүсийн анхааралд төдийлөн өртөөгүй олон бичвэрийг эмхэтгэж үзэх боломж бүхий болгосон нь ихээхэн чухаг ажил болжээ. Тэдний эл ажил нь зөвхөн эмхтгэлийн шинж чанартай бус харин судалгаа шингжилгээний ажлыг урагш ахиулах алхамуудыг хийсэн онцлогтой байна.

Тухайлбал, Хошуудын ойрад язгууртны гэр бүлд төрсөн, тод монгол бичгийг зохиогч Равжамба Зая бандида (1599-1662) шавь Раднаабдраагийнх нь 1690 онд бичсэн түүний намтарт³² дурьдсанчлан 1650-1662 оны хоорондох 12 жил буюу тод үсгийг зохиосон 1649-оноос нас барсан 1662 оныг хүртэлх хугацаанд гол төлөв шарын шашны гурван аймаг савын 170 бүтээлийг орчуулсан байна. Орчуулгын бусад 24 бүтээлийг түүний хамгийн ойрын шадар хамтрагчдад хамаатуулж үздэг. Эдгээр тоо баримт нь Зая бандидын орчин үеийн товч намтарт уламжилсантай тохирч буй. Хайсагийн үзсэнээр тийнхүү тохирч байгаа явдал бол Зая бандидын

³¹ N.Poppe, Stand der Kalmückenforschung, WZKM LII: 1955, 436-479

³² “Равжамба Зая Бандида тайжийн Сарны гэрэл хэмээх нэрт толь болой”. Ред. Б.Ринчин CSM V, 2, Улаанбаатар 1959, 13-19; “Монголын уран зохиолын дээжэс билиг”. Эмхтгэсэн С.Дамдинсүрэн. Улаанбаатар 1959, 320-328

амьд ахуй цагт 200 орчим бүтээлийг төвдөөс баруун монгол хэлэнд хөрвүүлсэнийг илтгэнэ. Монголын уран зохиолын түүх судлаач Ц.Дамдинсүрэнгийн мэдээлснээр баруун монгол хэл дээрх энэ олон орчуулгаас тун цөөн нь Ленинград дахь ЗСБНХУ-ын Шинжлэх Ухааны Академийн Дорно дахины судлалын хүрээлэн болон Улаанбаатарын Улсын номын сангийн цуглуулгад хадгалагдан үлджээ. Мөн Шинэ Делийн Рагу Вирагийн цуглуулга дахь Ленинградын сан хөмрөгийн баруун монгол эх хувиудын микрофишр хальс ч маш цөөн тоогоор байгаа болно. Баруун монгол гар бичмэлүүд ховордсоны шалтгааныг сүүлийн үеийн үйл явдлуудаас гадна XVIII зуунд манжуудын ойрадуудтай хийсэн аян дайнуудаас хайх хэрэгтэй болов уу хэмээн Хайсаг үзжээ. Тиймээс Германы цуглуулга дахь гар бичмэл, барын хэвлэлийн дотор олон тооны халимаг, ойрад гар бичмэл байгаа нь ихээхэн ач холбогдолтой, тухайлбал *Алтан гэрэл* зэрэг Зая бандидын хамгийн том орчуулгын бүтээлүүдийн хуулбар, түүхийн бүтээл болох *Гэгээн толь* буюу *Боди мор*, *Тарва чанбо* мөн тэнд байгаа *Medeki ünede ügeigi ilayuc̣i sudur* хэмээн нэрлэсэн *Үлгэрийн далай* тэдгээрийн дотор байгаа төдийгүй ертөнцийн үүсэл хөгжлийн талаарх бүтээл болох *Ертөнцийн толь*, *Мэтгэлцээний судар*, *Апарамитааюургяана (Цэданишбагмэд)*, *Aparamitāyurjñāna* (Цэнд судар) судар, Банзрагч судрын Тарнийн эмхтгэл, *Цогт зандан*, *Очироор огтлогч* судрын үлэмж олон тооны баруун монгол хэл дээрх хувилбар зэрэг бага хэмжээний орчуулгын бүтээлүүд байна.

Германд хадгалагдаж байгаа бүтээлүүдийн талаар зарим судлаачдын бичсэн зүйлд Хайсиг өөрийн саналыг хэлжээ. Үүнд тэрбээр, Чухамдаа Очироор огтлогч судар тод үсгээр олонтаа орчуулагдсаны дээр Ленинградын цуглуулгад уг бүтээлийн гар бичмэлүүд байдаг тул энэ судрыг халимаг хэл дээр ховор байдаг гэсэн У.Пошийн үзлийг няцаалгүй орхиж боломгүй гээд, Дээр дурьдсан багавтар хэмжээний бүтээлүүдийг бүгдийг нь Равжамба Зая бандида орчуулжээ. Түүний шарын шашны *судруудын* харьцуулсан тойм нь баруун монгол эх бүтээл болно. Жишээ нь: *Үлгэрийн далай* зэргийн монгол хувилбартай хийсэн харьцуулалтаас үзэхэд Зая бандида нэгэнт хийгдсэн монгол орчуулгыг баруун монгол хэлэнд тохируулан авч хэрэглэсэн бус харин төвдөөс жинхэнэ шинэ орчуулга хийж байсан нь харагдана. Энэ нь *Мани гамбум* -д ч хамаатай агаад түүний 1712 онд Бээжинд хэвлэгдсэн уйгуржин монгол хувилбар нь мөн л Зая бандидынх болно³³ гэжээ.

Мөн Энэтхэг-Төвдийн хүүрнэл зохиол ч баруун монголчуудын дунд ихэд дэлгэрсэн байна. Юутай ч монгол хэлээр өргөн дэлгэрсэн *Шидэт хүүрийн үлгэр*,

³³ Libr. Mong. 47; Heissig, Blockdrucke, Nr. 24

Арж Борж хааны түүх, хан хөвгүүн Артасиди болон Ушиандар хааны тууж халимаг хэл дээр байгаа нь үүнийг харуулна. Эдгээрт мөн “*Tüb oroni tusa büttügsen хан күбүн*”, *Оюу чихт* хан хөвүүний тухай тууж зэрэг түүхүүд, тэрчлэн Энэтхэг ахуй орчинд өрнөж буй үйл явдлыг харуулсан туужуудын цуглуулга багтана гэж үзжээ.

Ийм гарал үүсэлтэй туужуудын тоонд *Хүнд хилэнц арилгагч Манихар охин тэнгэрийн тууж* ч мөн орох болов уу? гээд, гэхдээ уг тууж монгол хэл дээр ч байдаг ба судрын сүүл хэсгийн тайлбарыг үндэслэн анхны хэлбэр нь монгол байсан гэж үзмээр байгаа юм хэмээжээ. Барон фон Аашийн цуглуулгын ачаар германчууд энэ бүтээлийн халимаг гар бичмэлийг олж авчээ.

Герман дахь монгол бичиг үсгийн дурсгалуудыг тодорхойлон бичихдээ дээр дурдсан зүйлүүд дээр нэмэрлэх нэгэн зүйл бол уг бүтээлүүдийн ач холбогдлыг цохон тэмдэглэсэн явдал юм. Тухайлбал, *Хүнд хилэнц арилгагч Манихар охин тэнгэрийн тууж*-ийн 1781 оны 3 сарын 2/13-ны өдрийн бүртгэлд дараах тайлбарыг хийжээ. “Дугаар 1. 23 хуудас монгол гар бичмэл, gros folio. Инээдмийн жүжиг ажээ. Луин хаан хэрхэн гуниж гутарсан тухай, Зилма Эрдэнийг гөрөөчин Тусатад өгөхөөс оор аргагүй болсон. Тэр сэтгэл татах чадвартай, Гинар хааны охин үзэсгэлэнт Манихарыг авмуй”. Энэхүү тэмдэглэл нь ердөө л халимаг зохиолын нүүр хуудсанд оросоор нэмэлт хийснийг орчуулсан хэрэг бөгөөд тэнд инээдмийн жүжгийг *комедии* гэжээ. Энэ нь уг бүтээлийг XVIII зуунд монголчууд найруулан тавьж байсныг нотолсон эдүгээг хүртэлх цорын ганц нотолгоо болохын дээр XVIII, XIX зууны үеийн эртний Монголын театрын талаарх бидний мэдлэгийг баяжуулж буй. 1770 оноос Бээжингийн барламал хэвлэл, олон тооны гар бичмэлээр дэлгэрсэн “*Саран хөхөө*”-ний намтар³⁴, Чойжид гэгч эмэгтэй ногоо ертөнцөд очоод буцсан тухай түүх болох *Эрдэнэ Чойжид дагинын намтар*³⁵ болон *Мял Богдын дуулууд*³⁶ ыг найруулан тавьж байсан нь л одоогоор мэдэгдээд байгаа юм. Мөн Очироор огтлогч судрын тус эрдмийг жишээн дээр харуулсан *Дорж зодовын тайлбар* нь Төвөдөөс үлгэр авсан байх магадлалтай туужуудын цуглуулга юм. Туужийн энэ цуглуулга XVII зууны бусад монгол орчуулгууд дотор ч бий бөгөөд тэдгээр нь Бээжин, Дели, Монгол болон Данид буй гэжээ.

Чингис хаантай холбоотой зохиол бүтээлийн насжилт, уламжлалыг тогтооход *Унд дарсны гэм, эрдмийн талаар есөн өрлөгтэй өнчин хөвүүний*

³⁴ Heissig, Blockdrucke, Nr 146; Г. Уварова, Современный монгольский театр, Ленинград 1947; Ч.Лодойдамба, Традиций монгольской драматургии, Современная Монголия, 1959

³⁵ W.Baruch, Un mystere tibetain: La Dame Tschokyid de Ling, Cahiers du Sud, 1928, 310-231; Ms. Kgl. Bibl., Kopenhagen, Mong. 424; Mong. 103; Bibl. Nationale, Paris

³⁶ Libr. Mong. 46 und 149; Heissig, Blockdrucke, Nr. 130 und 131

цэцэлсэн шастир болон шадар нөхдийн магтаал-ын гурван халимаг гар бичмэл мөн ач холбогдолтой, учир юун гэвэл тэдгээрийн наандаж хоёр нь XVIII зууных бөгөөд *Болор эрх*³⁷ зэрэг XVIII зууны монгол түүхэн шастируудтай тохирдогийн хувьд Чингис хаантай холбоотой ном зохиолын эдгээр хэсэг үндсэндээ монгол уламжлалаар бүтээгдсэн болохыг харуулна.

Монгол хэвлэлийн түүхийн хувьд халимаг барын дөрвөн тасархай хэсэг гойд сонирхол татаж буй зохиогчид тэмдэглэжээ. Тэдгээрээс гадна саяхан байгаагийн нь мэдсэн Ленинград дахь ЗСБНХУ-ын Шинжлэх Ухааны Академид буй хоёр халимаг барламал хэвлэл³⁸, мөн Ле Кокын тодорхойлсон³⁹ халимаг барламал хэвлэлийн тасархай, бүгд нийлээд халимаг барын 7 хэвлэл буюу тасархай хэсэг байгаа нь одоогоор мэдэгдээд байгаа бол П.С.Палласын халааг авсан Б.Лауфер 1907 он гэхэд л лав баруун монголчууд барын хэвлэл мэддэг, хэрэглэж дадсан гэдэгт эргэлзэж байсан билээ. Харин Очироор огтлогч судрын нэгэн халимаг гар бичмэлийн төгсгөл хэсгийн заалт халимаг барын хэвлэл хэдийнээс үүссэн талаарх учиг сэжүүрийг гаргаж өгөв. Түүнд 1712 онд Зүүнгарын ноён *Цэвээривдангийн* хүү *Галданцэрэнгийн*⁴⁰ хүсэлтээр ийм бүтээлийг барлаж хэвлэсэн тухай дурьдсан байв.

Мэргэ төлгийн сэдвээр бичсэн халимаг гар бичмэл үлэмж олон байна. Өдгөөг хүртэл ердөө хэдхэн монгол гар бичмэлийг үндэс болгож байсан монголчуудын мэргэ төлгийн аргыг шинжлэх ухааны үүднээс судлах судалгаа түүгээр оргожих болно хэмээн үзжээ. Урд нь Р.Бауден монголчуудын мэргэ төлөг хэрхэн хийдэг талаар бичсэн аж⁴¹.

Хайсаг Баруун монгол овог аймгууд, тэрчлэн 1675 оноос Ижил мөрөн, Дон морний доод хавиар нүүдэллэн амьдарч байгаа халимагууд монголчуудтай оюун санаагаараа нэгдмэл болохыг баруун ба зүүн монгол хэл дээрх ардын мөргөл залбирлын олон гар бичмэл нэн тодорхой нотлон харуулна гэжээ. Мэргэ төлгийн бичвэрийн дийлэнх нь Аашийн цулуулгад байгаагаар адил XVIII зууны 2 дугаар хагаст хийсэн цуглуулга буюу Юүлгийн цуглуулга дахь *бунханаас* олдсон тасархай хуудаснуудын он цагаас харагдаж байгаачлан XVIII зууны

³⁷ W. Heissig, *Bolur Erike*, Peking 1946, 59-74; C. Damdinsüreng, *Mongyol-un uran jokiyal-un teüke*, Mukden 1957, 150-160

³⁸ B. Ja. Vladimircov, *Vorwort zur Übersetzung der Lauferschen Skizze durch V. Kazakevic*, *Очерк монгольской литературы*, Ленинград 1927; N. Poppe: *Stand der Kalmückenforschung*, WZKM LII: 1955, 370

³⁹ A. Stein, *Innermost Asia*, Vol. II, 1049; Appendix K, *Inventory list of manuscript fragments in Uighur, Mongol, and Sogdian* by A. v. Le Coq, Nr. E. G. 021

⁴⁰ Гагаулина-Гольман-Слесарчук, *Русско-монгольские отношения 1607-1636*, Москва 1959, 303)

⁴¹ C. R. Bawden, *Astrologie und Divination bei den Mongolen - die schriftlichen Quellen*, ZDMG CVIII: 1958, 317-337; *On the Practice of Scapulimancy among the Mongols*, CAJ IV, 1-31

үеийнх байгаа нь ихээхэн ач холбогдолтой. *Цагаан өвгөний* дуудлага хамгийн олон байгаа нь их төлөв халимаг буюу монгол хэл дээрх бурханы шашны гурван аймаг савд багтдаггүй *Gajar usun-i nomiyadqan daulun čidayči neretü sudur* нэртэй судрын хуулбар болно. Мөн Гэсэрийн сан тахилгын судар харьцангуй элбэг байх бөгөөд түүнд Бээжинд барлан тараасан *Гэсэрийн убсанж* халимаг, монгол хувилбартай холбоотой зүйлс ч байна, бас Ринчений⁴² мэдээлсэн *Гэсэр хааны дуудлагаас* зөрсөн зүйлс ч байна гэжээ. Цуглуулганд буй мөргөл залбирлуудад монгол Гэсэр хаан туулийн IV дууллын нэмэлттэй хамт Гэсэр хааны нэр гарч байна. Мөн Гэсэр Богдын 12 зоосны мэргэ хэмээн мэргэ төлгийг түүний нэрээр нэрлэсэн нь ч байна. Бусад ардын мөргөл залбирал дотор бас монгол, халимаг *галын мөргөл*, Алтай уулын дуудлага, тэрчлэн *Буян хишигийн даллага* болон Өмнөд Монгол, Халх нутгийн *Хийморийн дарцаг* хийсгэхэд уншдаг мөргөл залбирал байна. *Хар Махагалыг* урин залж тахидаг Чингис хааны *Хар сүлдний* мөргөлийн хавсралтанд монголчуудын сүлдэнд хүнээр тахил өргөх тухай заасан байдаг ба энэ заншлыг бусад түүхэн баримтууд ч нотолдог⁴³ бөгөөд уг мөргөл залбирал мөн л Халх нутгийн⁴⁴ өөр нэг гар бичмэлд гардаг. Халх нутгийн өөр бас нэг *Сүлдний* залбиралд буддын шашны нөлөө орсон мэт. Шарын шашны бурхадын чуулсан оронд *Сүлд тэнгэрийг* системчлэн оруулсныг Бээжинд барласан нэгэн магтаалд ийн өгүүлжээ: Nasun-u бүтүгел амрита kundali-ača ariyuluči bičig gamuy jedker-i arilyauči kiged niyudayin ejen-ü gkyurgaysan sülde tngri-yi tegünčilen maytaqui. Халимаг ардын мөргөл залбирлын нэг хэсэг нь гар бичмэлийн цуглуулгуудад хадгалагдан үлдсэнийг мөргөл залбирлын ном гэж үзвэл зохино гэжээ. Монголчуудынх шиг байгалийн хүч нөлөөнд ихээхэн автсан аж төрөх ёсонд сахиусан хамгаалалт их үүрэг гүйцэтгэж байжээ гэж зохиогчид бичсэн амуй. Хэд хэдэн сахиус жинхэнэ эхээрээ байгаагийн дээр энэхүү шидэт хамгаалалтын талаарх үндсэн ойлголт төсөөллийг судлахад хэрэг болохуйц 60 сахиус хийх монгол заавар байх бөгөөд орц нь гол төлөв бие мах бодийн гаралтай ажээ.

Нэгэн зүйл

Бээжинд барласан шарын шашны олон ном шастир Германы цуглуулгын бас нэг гол хэсгийг бүрдүүлж байна. 1650-иас 1911 оныг хүртэл Бээжинд барласан Монголын шарын шашны орчуулгын ба тайлбар ном судруудаас одоог (1960-аад он, Ж.У.) хүртэл мэдэгдээд байгаа 230 гаруй бүтээлийн 168 нь Германы

⁴² En marge du culte de Guesser Khan en Mongolie, JSFOu LX: 1958, 3-51

⁴³ W.Heissig, Mongolisches Schrifttum im Linden-Museum, Tribus VIII: 1959, 41-50

⁴⁴ Rintchen, Les materiaux pour l'étude du chamanisme mongol, I, Wiesbaden 1959, 70

цуглуулгад орсон байна. Хайсиг тэдгээр ном шастир болон бусад 51 бүтээлийн талаар “Бээжинд барласан монгол хэл дээрх шарын шашны ном хэвлэл, монгол ном шастирын түүхийн материалууд” номондоо бичсэн аж⁴⁵. Тэдгээрийн сүүлийн тайлбарт нэрлэсэн хүмүүсийн нэрс хийгээд заасан учир шалтгаан нь Манжийн ноёрхлын үед Монголд хүчтэй нэвтэрсэн Төвдөөс гаралтай шарын шашин хэрхэн оюун санааны гүн гүнзгий нөлөө үзүүлснийг харуулна⁴⁶. Бээжингийн бархануудад барласан эдгээр бүтээл дээр 1870 оны үед ажиллаж байсан хамба лам *Вагиндра Сумади Галба Бадрада* (*Vagindra sumati kalpa bhadra dana*), *Агваанлувсангалсанжинба* (*Вагиндрасуматикалпабхадрадаана*)–н барлуулсан буюу түүний нөлөөллийн хүрээнд хэвлэгдсэн 38 буриад барын ном нэмэгдэнэ. Гэхдээ бас Эрдэнийн сан Субашидийн тайлбар *Чандманийн түлхүүр* зэрэг Цахарын *Цагаан уул* хийдийн хэвлэл, эсвэл Утай уулан дээрх Лө мү хөү си хийдэд барласан Бээжингийн анхдугаар Жанжаа хугагт Агваанчойндон (*Can skya Khutukhtu Ngag dban blo bzan chos Idan*)–ы сургаал зэрэг нь XVIII, XIX зуунд шарын шашны хэвлэл нийтлэлийн ажил илүү өргөн хүрээтэй явагдаж байсныг харуулна.

Энх-Амгалан хааны 17 дугаар агь, Гүо-и чин ван хэмээн алдаршсан хунтайж Иньли (1697-1738) Найралт төв (Юнчжэн) хааны хүрээлэлд Төвөд, шарын шашныг сайн мэддэг гэгдэж тэр чиглэлээрээ ажиллаж байсан агаад өөрийн хөхиүлэн дэмждэг Төвдийн шарын шашны бүтээл, ярианы дэвтэрийг монголчлох ажлаас гадна монгол хэл дээр зан үйлийн ном судар гаргахыг сонирхдог байжээ. Тантрын ёсны ид шидийн зан үйлийн нэгэн томоохон цуглуулга үүнийг нотолно. Түүний номын сангийн ийм гар бичмэлүүдийн өөр нэг хэсэг нь Кэмбрижийн Их сургуулийн номын санд⁴⁷ буй. Түүний тамгатай, ямагт нэг л хүний гараар гарчгийг нь монголчлон нэмж бичсэн байдаг төвөд бүтээлүүдийг Копенхаген дахь Хааны Номын сан болон Берлины улсын номын санд хадгалж байна.

XVIII зууны Монголын оюуны амьдралын тэргүүлэгч бие хүмүүсийн нэг, төвд сургуулийн захирал Үзэмчиний Гомбожав нь шарын шашин, хэлний шинжлэх ухаан, анагаах ухааны ном зохиол орчуулдгаараа, мөн түүхэн зохиол бүтээл туурвидгаараа алдаршсан нэгэн бөгөөд 1725 онд дуусгасан Хятадын Мин

⁴⁵ Wiesbaden 1954, cf. ferner: Die Libri Mongolei der Westdeutschen Bibliothek, Marburg, ZDMG CIII: 1953, 394-424

⁴⁶ W.Heissig, Das mongolische Publikations – und Übersetzungswesen der Mandju-Zeit, Sinologica III: 1953, 203-209

⁴⁷ C.R.Bawden, A first Description of a Collection of Mongol Manuscripts in the University Library Cambridge, JRAS, 1957, 151-160

улсын үеийн ёс суртахууныг номлосон буддын шашны судар Hsüan-ming-shuo-н орчуулга нь түүний ном зохиолын сонирхолтой танилцах боломжийг олгож байна.

Монголын буддын шашны гурван аймаг савын ном үүссэн түүх, XVII зуунаас XVIII зуунд шилжих шилжилт хийгээд Лигдэн хааны үе гэж алдаршсан оюун санаа, улс төрийн эрс өөрчлөлтийн үе (1604-1634)–ийн монголчуудын оюун санааны амьдралын талаарх мэдээллийг өөр нэг бүлэг гар бичмэл өгч байна хэмээн Хайсаг үзжээ. Тэрээр, Бүхэлд нь *Элдэв судар* хэмээн нэрлэсэн нэгэн томоохон гар бичмэлд Данжуурын *Локапрагьянти Lokaprajñapti* хэмээх ертөнцийн үүсэл хөгжлийн талаарх бүтээлийн орчуулгын хоёр хувилбар байгаа бөгөөд *Yirtinčü-yi nereidügsen* хэмээн нэрлэсэн нэгийг нь *Гүнтэн гүүш (Mayidari daigüng dayun günding)*, *Yirtinčü-dyüluysan* хэмээн нэрлэсэн нөгөөг нь *Дай гүүш (Dai güng sikü)* орчуулжээ. Хоёр хэлмэрч хоёулаа Лигдэн хааны монгол Ганжуурын редакцид ажиллаж байсан нь батлагдсан амуй. Данжуурын нэг бүтээлийг Лигдэн хааны үеийн хоёр хэлмэрч хоёр янзаар орчуулсныг нэг ботид оруулсан нь XVIII зууны дунд үед биш, харин бүр XVII зууны эхний хориод жилд монгол Ганжуурыг орчуулахад няхуур нямбай бэлтгэж байсныг харуулна. Үүнийг Данжуурын бусад бүтээлийн орчуулга ч батлана, тухайлбал Мадхямакопдэшанаама *Madhyamakopades, anāma* монгол Данжуур дээр ажиллаж байсан Лигдэн хааны ажилтан *Тойн сандүв* орчуулсан бол Дэвитарайкавимшатистотра *Devitāraikavimsatistotra* орчуулсан байна. Лигдэн хааны үед монгол Ганжуур дээр ажиллаж байсан нь батлагдсан, өөрөөр хэлбэл XVII зууны эхээр ажиллаж байсан орчуулагчид болох Гарма дубсан *Гарма дубсанг болон Хөх хотын алдарт хэлмэрч Ширээт гүүш цорж*-той холбоотойгоор нэр нь гардаг *Dayigung dayun sikü гүүш* зэрэг хүмүүсийн хийсэн бусад орчуулга XVI зуунаас XVII зуунд шилжих шилжилтийн үед орчуулгын ажил нэн идэвхтэй өрнөж байсныг гэрчилнэ. Эрдэнийн сан Субашид-ын тайлбарын одоог хүртэл мэдэгдээгүй байсан *Dayigung dayun sikü гүүш* орчуулга олноод байгаа бөгөөд түүнээс XIV зуунд *Соном гара*-н хийсэн тэрхүү алдартай дидактик бүтээлийн орчуулгыг *Dayigung dayun sikü гүүш* мэдэж байсан ба түүнээс ишлэл авч хэрэглэж байсан⁴⁸ нь тогтоогдож байна. Энэ бүх гар бичмэл нь XVI, XVII зууны үеийн монголчуудын оюуны амьдралын талаар бидэнд нэгэнт хэвшин тогтсон ойлголт төсөөллийг үлэмж гүнзгийрүүлж өгч буй хэмээн Хайсиг онцлон тэмдэглэжээ.

Brasi čirium увшанзийн даалгавраар *Гунгаа брази увш* гэгч хүний бичсэн монгол Ганжуурын Юмын аймгийн 12 ботийн нэг гар бичмэл 1718-1720 оны Ганжуурын барын мөн ижил хэсэгтэй бүх талаараа нарийн тохирч байгааг

⁴⁸ L.Liget, Le Subhasitaratnanidi Mongol, Budapest 1948

зохиогчид тэмдэглэжээ. Гагцхүү үг хэллэг нь ижил байхад толгой холбосон бадгуудынх нь дараалал ялимгүй өөрчлөгдсөнийг номын сүүл хэсгээс харж болно. Энэ нь Чингийн Энх-Амгалан хааны редакцийн комисс 1718-20 онд⁴⁹ Лигдэн хааны үеийн монгол Ганжуурын хувилбарыг өөрчлөлгүй тэр чигээр нь авч хэрэглэсэн гэсэн үг юм.

Улаанбаатарт⁵⁰ Санкт Петербургийн номын сангууд⁵¹ болон Копенхаген дахь Хааны номын санд түүхийн бүтээл их байгаа бол Германы цуглуулгуудад цөөн байна. Ийн бидэнд зөвхөн Төвдийн түүхэн шастир Жал-рав сал-вий мэ-лон (Gyal rabs gsal ba'i me long) халимаг орчуулга, буддын шашир дэлгэрснийг онцгой харгалзсан дэлхийн үүсэл хөгжлийн тухай монгол *Эрдэнэ зул Чингис хааны домог* болох төвд түүхэн бүтээл Сүмбэ Хамба Ишбалжир (Sum pa mkhan po dPag bsam ljon bzai)-ийн буриад лам Агваанлуvsангалсанжинба (Vagindra sumati kalpa bhadra dana)-ийн 1869 онд боловсруулсан буриад монгол хувилбар л байгаа нь түүхэн ач холбогдлоороо хоёрдугаар зэргийн бүтээлүүд болно. Халхын нэгэн бадарч ламын гарын номын сангийн бүтээлүүд дотроос олдсон уг бичвэрийн нэгээхэн хэсэгт *Саган сээрний Эрдэнийн товч* (1662) цэдгийн хэрхэн дэлгэрснийг сонирхолтойгоор товч тодорхой тайлбарласан байх ажээ. Харин ван гүнгүүдийн удам угсаа-түүхийн жагсаалт болох нэн ач холбогдол бүхий *Илтгэл шастир* бүрэн бүтнээрээ Мүгдэн болон Ленинград л хадгалагдан үлдсэн бол 1779 оны хамгийн өргөн хүрээг хамарсан анхны монгол хэвлэлээс юутай ч 28 ном байгаа ба 1858 оны товчилсон хэвлэл нь бүрнээрээ байна.

Монголын түүхэн болон хүүрнэл зохиолын хамгийн сонирхолтой, өвөрмөц дурсгалуудын нэг нь *Инжинаш* (1837-1896)-ийн "*Хөх судар*" -ын зохиогчийн өөрийн гараар бичсэн XV-XXIV дэвтэрийн гэрэл зургууд болов уу гэж Хайсаг үзээд, тэрээр цааш нь тэдгээрийг миний бие 1942 онд Баруун Түмэд хошуунд олдсон жинхэнэ эхийнх нь дагуу үйлдсэн билээ. *Инжинаш* уг бүтээлээ 1872 оноос өмнө туурвижээ. Хэвлэсэн хувьтайгаа тохирдоггүй *Хөх судар*-ын 43-72 дугаар бүлгийг агуулсан энэхүү жинхэнэ гар бичмэл эхээс хэвлэгдсэн нь үгүй бөгөөд зөвхөн *Инжинашийн* бичсэн өмнөтгөлийн зарим хэсгийг Өвөр Монголд тэрхүү гар бичмэл эхийн дагуу танилцуулсан байна⁵² гэсэн амуй.

⁴⁹ Heissig, Zur Entstehungsgeschichte der mongolischen Kandjur-Redaktion der Ligdan Khan-Zeit (1628-29), Studia Altaica, Wiesbaden 1957, 84-86

⁵⁰ Х.Пэрлээ. Монголын хувьсгалын өмнөх үеийн түүх бичгийн асуудалд. Улаанбаатар, 1958

⁵¹ Л.С.Пучковский. Монгольские рукописи и ксилографы Института Востоковедения. Москва 1957, 1-146

⁵² Erdenitoltagu, Injanasi, Köke Khota 1958, 33-53

Нэгэн зүйл

Германд хадгалагдаж буй архивын материал нь хэдийгээр их төлөв санамсаргүй тохиолдолоор, эмх замбараа муутай хийсэн цуглуулгын дүнд бий болсон ч Чин улсаас баримталж байсан монгол тайж ноёдод хэргэм, зэрэг, цол өргөмжлөх тогтолцооны талаар зарим ойлголтыг өгч байна. Халх нутгаас олдсон нэг боодол баримт бичиг дунд XIX зууны хоёрдугаар хагасын үеийн түүхийн материал байгаагийн дотор баривчлагдсан дээрэмчдийн өчиг мэдүүлэг ч байна. Зарим баримт бичиг шарын шашны сүм хийдийн захиргааны талаар сонирхолтой нарийн ширийн мэдээллийг агуулж байна. Тэдгээрт мөн *Их хүрээ*-ний сүм хийдүүдэд ирдэг мөргөлчид эмэгтэйчүүдийг буруугаар ашигладаг зэрэг зүй бус явдлыг нарийвчлан дүрсэлсэн байна.

Жич, хожмын үед холбогдох нэг мэдэлэл бол Э.Хэнишийн шавь Дийтрих Шэфер 1936-37 онд Япон, Бээжин, Хаалганд оюутан солилцоогоор явж байхдаа хэд хэдэн монгол ном шастир худалдаж авсаны дотор XVII зууны эхэн үеийн зарим ховор гар бичмэл байв. Тэдгээрийг зохиогчийн Бээжингээс 1943-45 онд худалдаж авсан, тэнд барласан 28 хэвлэл, монгол газрын зургууд болон баримт материал, тэрчлэн 1941, 1943 онуудад аялж явахдаа харчин болон сүрэгчин монголчуудаас авсан⁵³ буюу тэнд зургийг нь авсан таван гар бичмэлийн нэгэн адил мөн л Марбург дахь Баруун Германы номын сангийн цуглуулгад нийлүүлсэн байна. Тэрчлэн Марбург дахь Баруун Германы номын сангийн цуглуулгад нэмэгдсэн үнэ цэнэтэй зүйл бол Фрийдрих А.Бишоффын 1956-57 онд Зүүн Азид судалгааны ажлаар явж байхдаа олж авчирсан монгол гар бичмэл, барын хэвлэлүүд бөгөөд дотор нь XVII зууны эхэн үеийн ном шастирын ховор чухаг гар бичмэлүүд ч байх ажээ.

Үүнээс хойш Германд Монголын эртний гар бичмэл болон барласан ном шинээр ирээгүй байна.

Нэгэн зүйл

Ийнхүү Германы номын сангуудад монгол гар бичмэл, модон барын хэвлэл, газрын зургийг 200 шахам жил цуглуулсан түүхтэй, тэр бүхнийг олж авах ажил олон хүний хувь заяатай холбоотой. Германы сан хөмрөг дэх Монгол цуглуулгын тоо Копенхагены Хааны номын сангийн монгол ном шастирын цуглуулгаас давж буй⁵⁴. Германд хадгалагдаж буй тоо нь 180 гараад байгаа монгол газрын зургууд

⁵³ W.Heissig, Ostmongolische Reise, Darmstadt 1955

⁵⁴ CATALOGUE OF MONGOL BOOKS, MANUSCRIPTS AND XYLOGRAHS by Walther Heissig, assisted by Charles Bawden. The Royal Library Copenhagen 1971

Улаанбаатарын Улсын номын санд бүртгэлтэй 360 хувь⁵⁵ зургийн цуглуулгын дараах хилийн чанад дахь Монголын газрын зургийн хамгийн том цуглуулгуудын нэгд орж байгааг Хайсаг цохон тэмдэглэжээ.

Хилийн чанадад, тухайлбал ОХУ-д монгол бичиг номын асар их дурсгал хадгалагдаж байгаа билээ. Оросын ШУА-ийн Дорнодахины гар бичмэлийн фондод хадгалагдаж буй гар бичмэл болон барласан номны хамгийн их тоотой нь монгол судар ном бөгөөд 8 мянга гаруй хадгаламжийн нэгжтэй аж.⁵⁶ Тэдгээрийн эхнийхэн нь XVIII зууны тэргүүн хагаст тэндэхийн цуглуулганд оржээ. Хөрш зэргэлдээ байдал хийгээд Оросын эзэнт гүрэн хил хязгаараа тэлэх бодлого тус оронд Монгол судлал хөгжих нөхцлийг бүрэлдүүлжээ.

Хайсигийн тэмдэглэсэнээр Европ, Япон болон Америкт Монголын түүх, соёлд холбогдох ойролцоогоор 2,5 мянган ном судар хадгалагдаж байна⁵⁷ гэж тэмдэглэснийг Оросын судлаач А.Г.Сазыкин нэмэлт тодотгол хийж Хайсагийн орхигдуулсан Унгарын Шинжлэх ухааны Академи болон АНУ-ын Калифорны Беркли Их Сургуулийн цуглуулгыг оруулвал Европ, Америк болон Япон дахь цуглуулга 3 мянгад хүрнэ гэжээ⁵⁸. Эдгээр нь 39 төрлийн цуглуулганд ангилагдан байх бөгөөд эдвээр арвин их ном судар, бичиг баримт болон газрын зурагнуудын 3\2 нь л дөнгөж тодорхойлолт болон нэр дансанд ороод байгаа аж⁵⁹. БНХАУ-д хадгалагдаж буй монгол гар бичмэл болон модон барын ном судрын жагсаалт-каталогийг 1979 онд хэвлэн гаргасан бөгөөд тус улсад 60 нэр төрөл бүхий цуглуулганд 1,5 мянган зохиолыг агуулсан 7 мянган боть зохиол байна хэмээн бичжээ⁶⁰.

Ингээд Хайсигийн дурьдсанаар Монгол, Орос, Хятадыг оролцуулахгүйгээр Өрнө болон Дорнодод дараах газруудад монгол бичгийн ном судар хадгалагдаж байна. Үүнд: Копенхагены Хааны намын санд 560 монгол гар бичмэл ном судар хадгалагдаж байгаа билээ⁶¹ Мөн Бельгийн Брюсель болон Лаувены шашин номлогчдын цуглуулгад 46, Швейцарын Берны Түүхийн музейд шашны ном судар 45, Чикагогийн Их Сургуулийн Номын сангийн Алс Дорнодын хэсэгт 72,

⁵⁵ Улсын Номын сангийн Азийн ангид буй монгол ангийн бичмэл ба дармал ном бичгүүдийн бүртгэл. Улаанбаатар 1937, 90-132

⁵⁶ А.Г.Сазыкин. КАТАЛОГ МОНГОЛЬСКИХ РУКОПИСЕЙ И КСЕЛОГРАФОВ Института Востоковедения Академии Наук СССР. Том I, т.6, Москва

⁵⁷ В.Хайсиг. Копенгаген 1971, т. XIX-XX

⁵⁸ А.Г.Сазыкин. Дурьдсан каталог. Оршил хэсэг, т.6

⁵⁹ А.Г.Сазыкин. Мөн тэнд

⁶⁰ "Бүх улсын Монгол бичигийн номын гарчиг". Хөх хот 1979, т.3

⁶¹ Вальтер Хейсиг, Чарл Бауден. Дурьдсан каталог ном, т.19

Германд 12 цуглуулганд 672 ном судар, Финландын Хельсенкийн Их Сургуулийн Номын санд 89, Японы Киотогийн Их Сургуульд монгол Ганжуур Данжуурын 49 боть, Британы музейд 105, Лондонгийн Дорно дахин болон Африк суллалын сургуульд 34, Кембрижийн Их Сургуулийн номын санд 35, Шведийн Стокхольмын Угсаатны музейд 126, Токиогийн Тооё Бункод 230, Вена дахь Австрийн Үндэсний музейд 28, АНУ-ын Конгрессийн номын санд 81, Парисийн Улсын номын санд 165, Парисийн Гүйетийн музейд 3, АНУ-ын Принстоны Их Сургуулийн Хятад судлалын номын санд 109 боть монгол Ганжуур, Ирландын Дублин Честер Бейти Номын санд 52 ном судар хадгалагдаж байгаагаас гадны Йель, Харвард болон Нью Йоркийн Метрополитаны номын санд Монголын түүх соёлын дундад үед холбогдох бүтээлүүд мэр сар байна.

Ийнхүү Монголын соёлд холбогдох арвин их ном судар цуглуулагчид болон судлаачдын гараар дамжин тэртээ XVIII-XX зууны эхэнд хилийн чападад гарч, улмаар дээр дурдагдсан орнуудын номын өргөөнүүдэд хадгалагдаж байгаа нь Монгол судлал олон оронд хөгжих нэг үндэс суурь болж өгсөн гэж үзүүштэй. Нөгөө талаар XX зуунд колоничлол нуран унаж, дэлхийн хөнөөлт I, II дайн дэглэж, улмаар улс орнуудын хөгжил шинэ дэвшилтэнд харилцаанд шилжсэн нь бусдын соёлын өвийг дураар зөөвөрлөх явдалд цэг тавьжээ. Хэдүй тийм ч гэсэн аливаа орноос соёлын өв гадагш янз бүрийн замаар гарах явдал байх боловч (ялангуяа социализмаас зах зээлийн харилцаанд шилжих үед-Ж.У.) нөгөө талаас соёлт ертөнцөд хулгайн замаар ирсэн зүйлийг хүлээн авах газар ч (хууль дүрмэндээ захирагдан- Ж.У.) бараг үгүй болжээ.

Abstract: The Mongolian studies in Germany began to develop in the 19th century. Scholars such as Heinrich August Zwick, Wilhelm Schott, Erich Haenisch, Julg Bernhard have played major role in the development of Mongolian studies. Another factor that helped to develop this study of discipline is that Germany has the second biggest Mongolian collection of manuscripts and books in Europe. Most of the historical Mongolian manuscripts are located in twelve locations in Germany. Most of these manuscripts were brought to Germany in the 18th and 19th century. Very few have brought in the 20th century. These were brought via collectors from Germany. Heissig and Zagaster have written a catalog of these collections that are stored in Germany. I want to use their book as foundation for my article about Mongolian manuscripts and books that is stored in Germany. The article will investigate how these manuscripts were brought to Germany and what are contents of these manuscripts and books.